



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 08 сарын 30 өдөр

Дугаар А/349.


Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, Сангийн сайдын 2018 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 177 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сангийн сайдын 2018 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн “Зураг төслийн ажлын жагсаалт батлах” тухай 177 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Хүүхдийн эмнэлгийн зураг төсөл 50 ор /Увс, Улаангом/ 60,000,0000 /жаран сая/ төгрөгийн зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, төсвийг зарцуулах эрх /гэрээ байгуулах, сунгах, цуцлах, хяналт тавих, санхүүжүүлэх/-ийг Увс аймгийн Засаг дарга /Д.Батсайхан/-д шилжүүлсүгэй.
2. Эрх шилжүүлсэн төсөл арга, хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журам, зааврын дагуу шуурхай зохион байгуулж, гэрээ байгуулах, зураг төсөв хүлээн авах, хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч ажлын гүйцэтгэлийг тайлагнаж ажиллахыг Увс аймгийн Засаг дарга /Д.Батсайхан/-д даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч /Э.Содномжамц/-д үүрэг болгосугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

081422